



ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЛИЙН АУДИТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2026 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал болон Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

- Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;
- Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх;

ТӨРИЙН САНГИЙН ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ

№	Байгууллагын нэр	Гүйлгээний тоо		
		2023	2024	2025
1	Төв аймгийн Төрийн сан	25,821	32,419	27,107
2	Төв аймгийн 27 сумын Төрийн сан	44,657	93,982	82,870
Нийт дүн		70,478	93,982	82,870

Аймгийн Төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэн, 27 сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдийн хянасан гүйлгээний тоо

Төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын ачааллыг 3 жилийн дунджаар авч үзвэл:

·Аймгийн төрийн сангийн нэг мэргэжилтэн дунджаар жилд 14,224 ажил гүйлгээ, сард 1,185 ажил гүйлгээ, өдөрт 56 ажил гүйлгээ хийсэн байна.


·Сумын төсөв, төрийн сангийн нэг мэргэжилтэн дунджаар жилд 2,000 ажил гүйлгээ, сард 166 ажил гүйлгээ, өдөрт 8 ажил гүйлгээ хийсэн тооцоо гарч байна.

ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БҮЙ ЭСЭХ

Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөв, төсвийн хуваарь, хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байна.

Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажин, нэгдсэн хяналттайгаар хэрэгжиж байна.

№	Байгууллагын нэр	Буцаагдсан гүйлгээний тоо		
		2023	2024	2025
1	Төв аймгийн Төрийн сан	107	2,602	2,523
2	Төв аймгийн 27 сумын Төрийн сан	3,458	3,848	3,118
Нийт дүн		3,565	6,450	5,641





ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЛИЙН АУДИТ

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

ДҮГНЭЛТ

№	АЛДАА, ЗӨРЧИЙН ТОВЧ УТГА	МӨНГӨН ДҮН (сая төгрөг)	АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ГАРГАСАН ШИЙДЭЛ
1	Төсөвт байгууллагуудад “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.13 дахь заалтын дагуу амлалт, үүргийн бүртгэл хөтөлдөөгүй байна.	-	Зөвлөмж өгөх
2	2023-2025 онд зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн 1,266.4 сая төгрөгийн 1,391 гүйлгээг хянаж, баталгаажуулан гүйлгээг хийсэн байна.	1,266.4	Зөвлөмж өгөх
3	Төлөвлөгөөв дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг нарийн тайлангагүй, өдөр тутам хийгдэж байгаа хяналтаар залруулсан алдаа, шийдвэрлэсэн асуудал, өгсөн зөвлөмжийг баримтжуулан тайлагнаагүй байна.	-	Зөвлөмж өгөх
4	Сангийн сайдын 2015 оны 80 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажлын үйл ажиллагааны журам”-ын 1.4.15-д заасны дагуу, төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж тайланг улирал тутам гаргаж Сангийн яаманд хүргүүлж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгөх

Төсвийн тухай хуульд төрийн сангийн салбар, нэгжүүдийг ЗДТГ-ын дэргэд байхаар заасан ч ЗГ-ын тогтоолоор ЗДТГ-ын бүтцэд байхаар баталсан байна. Энэ нь төрийн сан төсвийн хэрэгжилтийг хангах, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг гүйцэтгэх, төлбөр тооцооны гүйлгээ хийх, тайлагнах үйл ажиллагааны хараат бус байдлыг алдагдуулж байна

Аймаг болон сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын ачааллын харьцангуй байдал, Цахим системд шилсэн, “Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт”-аар санхүүждэг босоо тогтолцоотой байгууллагуудын нягтлан бодогч нар байгууллагадаа харьяалагддаг болсон зэргээс шалтгаалан төрийн сангийн тогтолцоог шинэчлэн зохион байгуулах шаардлагатай байна

Төрийн сангийн цахим системд шилжсэнээр цаг хугацаа хэмнэх, хяналт сайжрах, механик алдаа гарах магадлал багасаж, системүүдийн уялдаатай байдал нь үйл ажиллагааны үр дүн сайжрахад нөлөөлсөн байна.

Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан ч хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал буурахгүй байгаа нь зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцохгүй байгаатай холбоотой байна.

ЗӨВЛӨМЖ

- ✓ Төсөвт байгууллагуудад “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.13 дахь заалтын дагуу амлалт, үүргийн бүртгэл хөтлүүлэх.
- ✓ Төрийн сан төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хүлээн авч шалган баталгаажуулж байгаа нь хяналтын үйл явц хэрэгжиж байгааг харуулж байна. Цаашид төрийн сангийн систем, байгууллагын санхүүгийн программ, төсвийн гүйцэтгэлийн мэдээний цахим баталгаажуулалтыг уялдуулж, төсөв хоорондын тооцоо, тохируулгын тайланг хугацаа, зөрүү, залруулгын бүртгэлээр тусад нь хянах шаардлагатай байна.
- ✓ Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 1.4.15-д заасны дагуу, төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж тайланг улирал тутам гаргаж Сангийн яаманд хүргүүлж ажиллах.
- ✓ Төрийн сангийн дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах, өдөр тутам хийгдэж байгаа хяналтаар залруулсан алдаа, шийдвэрлэсэн асуудал, өгсөн зөвлөмжийг тайлагнан баримтжуулах, зөрчил гаргасан мэргэжилтнүүдэд хариуцлага тооцож байх.